



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2023 оны 09 сарын 21 өдөр

Дугаар 450

Улаанбаатар хот

**Үндсэн хөрөнгө нээлттэй дуудлагын
худалдаагаар худалдах зөвшөөрөл олгох тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны "Төрийн өмчийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийн дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай" 268 дугаар тогтоолын 4.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа байгууллагын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, цаашид ашиглах боломжгүй болсон, нийт 547,003,006.47 (таван зуун дөчин долоон сая гурван мянга зургаан төгрөг дөчин долоон мөнгө) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий 22 автомашиныг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтад заасны дагуу тогтоосугай.

2.Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга П.Сайнзориг, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дарга, хурандаа О.Амарсанаа болон тогтоолд заасан байгууллагуудын дарга нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Үндсэн хөрөнгийг дуудлагын худалдаагаар худалдах ажлыг холбогдох хууль тогтоомж, захиргааны актын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Дуудлагын худалдааг зохион байгуулах үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулах, дуудлагын худалдаанаас олох орлогыг (дуудлагын худалдааны зардлыг хассан дүнгээр) зохих журмын дагуу улсын төсөвт төвлөрүүлэх;

2.3.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.4.Автомашиныг худалдсаны дараа улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлээс шилжүүлж, арга хэмжээний биелэлтийг холбогдох мэдээ тайлангийн маягт, хөрөнгийн үнийг төвлөрүүлсэн баримтын хамт 2023 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх;

3.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТЭСИЙН ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Д.НАРАНГЭРЭЛ

132005633
23-r_huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2023 оны 09 дугаар сарын 24-ны өдрийн
Үндэс дугаар тогтоолын хавсралт

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ЕРӨНХИЙ ГАЗРЫН ХАРЬЯА БАЙГУУЛЛАГЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД
БҮРТГЭЛТЭЙ, НЭЭЛТТЭЙ ДУУДЛАГЫН ХУДАЛДААГААР ХУДАЛДАХ АВТОМАШИНЫ ЖАГСААЛТ

Д/д	Үндсэн хөрөнгийн нэр, марк	Ашиглалтад орсон, дахин үнэлсэн он	Хэм жиж нэгж	Тоо хэм жээ	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Балансын нийт үнэ, хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Худалдах доод үнэ (төгрөг)
1. Дархан-Уул аймаг дахь ШШГГ-445-р хорих анги							
1	Соната-7 /24-99 УБУ/	2018	ш	1	31,713,397.00	31,713,397.00	5,000,000.00
2	Гранд марк 2 /30-40дах/	2016	ш	1	8,000,000.00	8,000,000.00	3,500,000.00
	дүн			2	39,713,397.00	39,713,397.00	8,500,000.00
2. Баян-Өлгий аймаг дахь ШШГГ							
1	Уаз-31512 /60-24 БӨА/	2010	ш	1	17,800,000.00	17,800,000.00	3,500,000.00
2	Ландкрийзер-80 /81-07 БӨА/	2009	ш	1	26,300,000.00	26,300,000.00	7,500,000.00
3	Приус-20, 83-31 БӨА	2016	ш	1	12,000,000.00	12,000,000.00	3,500,000.00
4	Фургон /21-14 БӨА/	2014	ш	1	31,000,000.00	31,000,000.00	3,500,000.00
	дүн			4	87,100,000.00	87,100,000.00	18,000,000.00
3. Өмнөговь аймаг дахь ШШГГ							
1	Приус-20 /0021-ӨМҮ/	2016	ш	1	9,500,000.00	9,500,000.00	3,500,000.00
2	Фургон /24-71 ӨМА/	2014	ш	1	31,000,000.00	31,000,000.00	3,500,000.00
	дүн			2	40,500,000.00	40,500,000.00	7,000,000.00
4. ШТН-ТӨҮГ							
1	Самосвал /45-61 ТӨА/	2010	ш	1	8,000,000.00	8,000,000.00	8,000,000.00
3	Экскаватор /41-78 УБ/	2013	ш	1	175,000,000.00	175,000,000.00	9,000,000.00
4	Пад трактор	2015	ш	1	1,400,000.00	1,400,000.00	1,200,000.00
	дүн			3	184,400,000.00	184,400,000.00	18,200,000.00
5. Өвөрхангай ШШГГ							
1	Фургон /13-01ӨВА/	2016	ш	1	25,500,000.00	25,500,000.00	3,500,000.00
	дүн			1	25,500,000.00	25,500,000.00	3,500,000.00

6. Замын-Үүд дахь ШШГХ						
1	Фургон-УАЗ /89-67/ ДГО	2008	ш	1	31,659,574.47	3,500,000.00
2	Жийп Хятад /87-88/ ДГО	2011	ш	1	18,975,000.00	7,500,000.00
	Дүн			2	50,634,574.47	11,000,000.00
7. Үйлдвэр барилга аж ахуйн хэлтэс						
1	Хьюндай грейс /90-53УНП/	2014	ш	1	8,000,000.00	4,800,000.00
2	Маяти крантай /16-84 УНА	2014	ш	1	10,600,000.00	12,000,000.00
	Дүн			2	18,600,000.00	16,800,000.00
8. Багануур дахь ШШГХ						
1	Киа серано /02-17УНУ/	2013	ш	1	33,000,000.00	7,500,000.00
2	Дүн			1	33,000,000.00	7,500,000.00
9. Газар-Ивээл ТӨААТҮГ						
1	Старекс /20-84 УНБ/	2016	ш	1	12,220,000.00	8,000,000.00
	Дүн			1	12,220,000.00	8,000,000.00
10. Орхон аймаг дахь ШШГХ 437-р Нээлттэй хорих анги						
1	Трактор Пад пад	2012	ш	1	3,000,000.00	1,100,000.00
2	Фургон-УАЗ /04-37ОРХ/	2010	ш	1	18,100,000.00	3,500,000.00
3	Портер /68-67ОРХ/	2010	ш	1	3,235,035.00	2,500,000.00
	Дүн			3	24,335,035.00	7,100,000.00
11. Говьсүмбэр аймаг дахь ШШГГ-425-р Нээлттэй хорих анги						
1	Фургон /09-46 ГСА/	2014		1	31,000,000.00	3,500,000.00
	Дүн			1	31,000,000.00	3,500,000.00
22	НИЙТ ДҮН			22	547,003,006.47	109,100,000.00